

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

**ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ  
БАЛДАНДОРЖИЙН ИТЭШМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
1	2	3	4	5	6	7	

**Зорилт 1. “Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх” зорилтын хүрээнд**

1.	Төрийн албаны салбар зөвлөлөөс гаргасан тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийн талаар танилцуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	Төрийн албаны салбар зөвлөлөөс шалгалтын комисс байгуулах тухай, төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд нэр дэвшиүүлэх тухай 9 тогтоол гаргаж, хэрэгжилтийг хангалаа.	1-12 сар	100%
2.	Сул орон тооны мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргэх ажлыг зохион байгуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшиүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу шилжин ажиллах зар болон тусгай шалгалтын зарыг Төрийн албаны зөвлөлийн <a href="http://www.csc.gov.mn">www.csc.gov.mn</a> болон байгууллагын <a href="http://www.ecustoms.gov.mn">www.ecustoms.gov.mn</a> цахим хуудсаар зарлаж, олон нийтэд мэдээллийг хүргэж байна. Төрийн албаны зөвлөлд 533 сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлуулахаар хүсэлт хүргүүлж, зарлуулав.	1-12 сар	100%
3.	Тусгай шалгалтыг 3 удаа зохион байгуулж, 300-аас сул орон тоог нөхөх	Улиралд 1 удаа	100%	100%	Тусгай шалгалтыг 4 удаа зохион байгуулж, 533 сул орон тоонд тусгай шалгалт зарлуулж, 180 сул орон тоо буюу 33,7 хувийг нөхлөө. Нийт 180 иргэнийг томилуулахаар салбар зөвлөлийн тогтоолоор нэр дэвшиүүлснээс 10 иргэнийг Авлигатай тэмцэх газрын мэдэгдэл, эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй болон өөрөө томилогдооос татгалзсан зэрэг шалтгаанаар томилоогүй болно. Шилжин ажиллах зарын дагуу төрийн бусад	1-12 сар	100%

					байгууллагаас 30 албан хаагчийг шилжүүлэн ажиллууллаа.		
4.	Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулж, ТАЗ-өөс батлах зөвшөөрөл авах	Батлах зөвшөөрөл авсан байх	80%	100%	Албан тушаалын тодорхойлолт шинэчлэх болон шинээр боловсруулах ажлын хэсгийг Гаалийн ерөнхий газрын даргын 2024 он 02 дугаар сарын 01-ний өдрийн А/103 дугаар тушаалаар 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Мөн 02 дугаар сарын 06-ны өдрийн 01-1.1/475 дугаар албан бичгээр Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон дэргэдэх байгууллагаас саналыг авлаа. Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөг баталж, шинэчлэн батлуулах албан тушаалын тодорхойлолтыг хариуцсан албан хаагчид хянаж, харьцуулалтыг хийж, холбогдох газар, нэгжийн дарга нараар хянуулсан. Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Татвар орлогын газар, Зөрчилтэй тэмцэх газар, Мэдээллийн технологийн газар, Статистик, дүн шинжилгээний хэлтэс, Хүний нөөцийн хэлтэс, Олон нийттэй харилцах албаны албан тушаалын тодорхойлолтыг шинээр болон шинэчлэн боловсруулж, хугацаанд бэлэн болгож, албан тушаалын тодорхойлолтын маягтын дагуу бэлтгэн, хэвлэхэд бэлэн болгож, тайланг бичив. Мөн Гаалийн байгууллагад ажилд ороход тавигдах шаардлага"-ын төслийг төрийн тусгай чиг үүргийн байгууллагад тавигддаг шаардлагатай уялдуулан боловсруулж, Хуулийн хэлтэст хүргүүллээ. Төрийн үйлчилгээний 6 албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулж, хариуцсан албан хаагчид хүргүүлэв. Үүнд: жолооч, мужаан, цахилгаанчин, гагнуурчин, тогооч, бэлтгэгч.	1-12 сар	100%
5.	Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг хамруулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	100%	Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/254, 2024.09.04-ний өдрийн 01/3545 дугаар албан бичгүүдээр төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2 албан	1-12 сар	100%

					хаагчийг улсын төсвийн санхүүжилтээр Удирдлагын академид суралцаж байна. Мөн төрийн албандаа анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх болино хугацааны сургалтад 5 албан хаагч хамрагдаж байна. Албан хаагчдыг тасралтгүй сургах, цаг үеийн эрэлт шаардлагад нийцсэн мэдлэг, чадварыг олгох, салбарын мэргэшсэн албан хаагчдыг шатлан дэвшүүлэх зорилгоор 2024.01.24-ний өдрийн 01/314, 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/3658 дугаар албан бичгүүдээр эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 64, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 14 албан хаагчийг хамруулах хүсэлтийг хүргүүлж, хамруулаад байна. Удирдлагын академиас хэрэгжүүлж буй “Амжилт бол сонголт” эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрт Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газраас 4, Сургалтын төвийн 1 албан хаагч хамрагдсанаас 1 албан хаагч шилдэг оролцогчоор шалгарч дараагийн шат буюу БНСҮ-д болино хугацааны сургалтад хамрагдлаа.		
6.	Жендерийн эрх тэгш байдал, төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	100%	100%	Жендерийн эрх тэгш байдлыг хангах гаалийн байгууллагын дэд салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг З зорилтын хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн батлуулж, биелэлтийг Хяналт шинжилгээ, дотоод аудитын газарт хүргүүллээ. Гаалийн байгууллагын албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан Жендерийн талаарх мэдээлэл болон Ажлын байрны бэлгийн дарамт, жендерийн тэгш байдал, ялгavarлан гадуурхатай холбоотой гомдлыг хүлээн авах талаарх мэдээллийг CERP системд байршууллаа. Жендерийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад хэрэгжүүлэх жендерийн стратегийн үнэлгээ”-ний талаар техникийн зөвшилцэх сургалтад 15, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны оны 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний	1-12 сар	100%

				<p>төлөвлөгөө (2024-2027)"-г танилцуулах арга хэмжээнд 10 албан хаагч тус тус оролцлоо. Мөн Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдан байгууллага, агентлагийн "Жендэрийн стратеги 20169-2024" дунд хугацааны стратеги нь энэ онд дуусаж байгаатай холбогдуулан Жендэрийн үндэсний хорооноос "Жендэрийн стратегийн үнэлгээ"-г хийж байгаа бөгөөд тус үнэлгээний хүрээнд Улаанбаатар хот дахь гаалийн газрын 10 албан хаагчтай Жендэрийн үндэсний хорооны зөвлөх ажилтан фокус ярилцлага хийлээ. Энэхүү үнэлгээ хийгдсэнээр тус стратегийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, хийгдээгүй үлдсэн зорилт арга хэмжээг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Мөн Татварын ерөнхий газрын Жендэрийн бодлого, төлөвлөлтийн талаар туршлага судалсан болно. Харьяа гаалийн газар, хороодод Жендэрийн асуудлыг хариуцах албан хаагчдын судалгааг гаргалаа. Одоогийн байдлаар харьяа гаалийн газар, хороодод 7 өөр чиглэлийн албан тушаал дээр ажиллаж байгаа албан хаагчид Жендэрийн асуудлыг давхар хариуцан ажиллаж байгаа бөгөөд тухайн албан хаагчийн албан тушаал өөрчлөгдөх тохиолдолд дахин өөр албан хаагчид хариуцуулах, улмаар ажлын хийдэл үүсэх нөхцөл бий болохоор байсан. Иймд харьяа гаалийн газар, хороодын Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод дараах 2 чиг үүргийг нэмж, албан тушаалын тодорхойлолтод тусган батлуулахад бэлэн болголоо. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороо, хүний эрхийн үндэсний комиссын хамтарсан 2021 оны А/107, А/02, 202, 02/009 дүгээр тушаалаар Төрийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн "Үлгэрчилсэн заавар"-ыг баталж, төрийн бүх шатны байгууллагын удирдлагад даалгасан тул Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн</p>	
--	--	--	--	--	--

					A/226 дугаар тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д холбогдох заалтыг шинээр нэмэх, хасах, өөрчлүүлэх талаар дараах саналыг Хүний нөөцийн хэлтсийн 2024.08.29-ний өдрийн 223 дугаар дотоод зурвасаар хүргүүллээ. Жендерт сууринсан хүчирхийлэлтэй тэмцэх “Шалтаг бүү тооч-Охид, эмэгтэйчүүд хаана ч аюулгүй” 16 хоногийн аяны талаарх мэдээллийг харьяа гаалийн газар, хороодод хүргэн, Гаалийн байгууллага тус аянд нэгдлээ. Аяны хүрээнд байгууллагын цахим хуудсаар постер хийн мэдээллийг нийтэллээ.		
7.	Харьяа гаалийн газар, хороодод ажиллаж байгаа албан хаагчдаас “Сэтгэл ханамжийн судалгаа” авсан байх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	Гаалийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр гарч буй хүндрэл бэрхшээл болон тулгамдсан асуудлыг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг боловсруулах зорилгоор 32 асуулгыг боловсруулан судалгааг цахимаар авлаа. Судалгаанд 968 албан хамрагдсан бөгөөд судалгааны нэгтгэлийг хийн танилцуулж, CERP системд байршуулав.	1-12 cap	100%
8.	Өргөдөл гомдолыг судалж, холбогдох шийдвэр гаргуулах, хариуг хуулийн хугацаанд өгөх	Өргөдөл гомдол, хүсэлт шийдвэрлэг дсэн байна.	100%	100%	Edoc системд бүртгэгдсэн 10 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, албан бичгээр хариу өглөө.	1-12 cap	100%
9.	Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл боловсруулах	Төсөл боловсруулж , батлуулж, хүргүүлсэн байна.	100%	100%	Гаалийн захиргаа, дотоод ажлын систем (CERP) -ээр ирсэн 87 албан бичгийг шийдвэрлэж, 39 албан бичгийн төсөл боловсруулж, 20 дотоод зурвасын төсөл боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.	1-12 cap	100%

**Зорилт 2. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг уургийг хэрэгжүүлж ажиллах**" зорилтын хурээнд

1.	Төрийн жинхэнэ албан хаагийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт хангах.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	100%	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны төлөвлөгөөнд “Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх” зорилтын хүрээнд 9, төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийн хүрээнд 3, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх 2 арга хэмжээг тус тус төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	1-12 сар	100%
2.	Үүрэг даалгаврын биелэлтийг хангах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	100%	100%	<p>Төрийн албаны зөвлөлийн 2024 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн аудитын сэдэв, төлөвлөгөөнд тусгагдсан “Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитын хүрээнд Гаалийн байгууллагад ажиллаж байгаа мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлдэг албан хаагчдын судалгаа, мэдээллийг гарган ажиллалаа. Төрийн албаны зөвлөлд 2017-2024 он хүртэл байгууллагын бүтэц, орон тооны дээд хязгаарын судалгаа, төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр газар, нэгжүүдэд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн судалгааг нэгтгэн хүргүүллээ.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс боловсруулсан 3 журмын төсөлд газар, нэгжээс ирүүлсэн саналыг нэгтгэн хүргүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлага, албан тушаалын тодорхойлолт боловсруулах, хянах, зөвшөөрөл олгох, батлах нийтлэг журам</li> <li>- Төрийн албаны салбар зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам</li> <li>- Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам</li> </ul> <p>Үндэсний аудитын газраас ирүүлсэн хүснэгтийн дагуу албан хаагчдын болон албан тушаалын мэдээлэл (мэргэжил, туршлага, ажилласан жил, цалин хөлс, сургалт..г.м), томилогдсон, чөлөөлөгдсөн, сэлгэсэн, шилжсэн, шүүхийн шийдвэрээр эргүүлэн томилсон зэрэг</p>	1-12 сар	100%

						дэлгэрэнгүй судалгааг 2013, 2016, 2019, 2022, 2023 оныг гаргасан бөгөөд судалгааг тушаал, Гаалийн захиргаа, дотоод ажлын систем (CERP)-ээс гаргав.		
3.	Ажлын ашиглалтыг цаг сайжруулах	Хоцролт, таслалт, цаг ашиглалтын байдал	100%	100%	Өдөр бүр цаг бүртгэлийн системд бүртгүүлэн, ажлыг цаг ашиглалтыг сайжруулан ажиллалаа.	1-12 сар	100%	

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Хүний нөөцийн чиглэлийн хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулсан байх	Сургалтын тоо	-	Сургалтад хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөлийн цахим сургалтад хамрагдav. Мөн МУИС-ийн ХЗС-ийг төгсөв.	1-12 сар	100%
2.	Монгол бичгийн мэдлэгээ сайжруулсан байх	Сургалтын тоо	-	Сургалтад хамрагдсан байна.	Монгол бичгийн цахим сургалтад 2 удаа хамрагдav.	1-12 сар	100%

**ТАЙЛАН ГАРГАСАН:**  
**ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН**  
**УЛСЫН БАЙЦААГЧ**

Б.ИТЭШМАА

2024.12.10

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
8 дугаар хавсралт

**ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ  
БАЛДАНДОРЖИЙН ИТЭШМААГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,  
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
Нэгжийн нэр: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
					1
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

**Зорилт 1. "Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх" зорилтыг  
хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт**

1.	Төрийн албаны салбар зөвлөлөөс гаргасан тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийн талаар танилцуулах	40	6	46	53
2.	Сул орон тооны мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргэх ажлыг зохион байгуулах	60	10	70	70
3.	Тусгай шалгалтыг 3 удаа зохион байгуулж, 300-аас сүл орон тоог нехөх	50	5	55	55
4.	Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулж, ТАЗ-өөс батлах зөвшөөрөл авах	43	5	48	56
5.	Үдирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг хамруулах.	60	10	70	70
6.	Жөндэрийн эрх тэгш байдал, төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах	40	5	45	45
7.	Харья гаалийн газар, хороодод ажиллаж байгаа албан хаагчдаас "Сэтгэл ханамжийн судалгаа" авсан байх	40	5	45	45
8.	Өргөдөл гомдлыг судалж, холбогдох шийдвэр гаргуулах, хариуг хуулийн хугацаанд өгөх	60	10	70	70
9.	Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл	49	5	54	54

2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	90.0
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	2.7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	3.7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	74
<b>Нийт оноо =</b>		
( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		
		69.4

Үнэлгээ өгсөн:

ХҮНИЙ НӨӨЦИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Нэгжийн дарга

Ж.БАЯСГАЛАН

2024.12.19  
(огноо)

Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН  
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

Төрийн жинхэнэ албан хаагч:

Б.ИТЭШМАА  
2024.12.26  
(огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДЭД ДАРГА

Г.ЭНХТАЙВАН

2024.12.26  
(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ХҮНИЙ НӨӨЦИЙН  
ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

Ө.ТЭГШЭЭ

2024.12.20  
(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

2024.12.20  
(огноо)